



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талуудын эрх үүргийг бусад хууль тогтоомж, журамтай хэрхэн нийцүүлж болохыг тодорхойлох зорилгоор ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсонтой холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талууд болон хуулийн байгууллагуудтай хамтарсан уулзалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ч.Оюунцэцэг /Дэд дарга, дэд хурандаа/

Гишүүд:

Н.Уранчимэг /Ахлах гүйцэтгэгч, хошууч/

Ц.Бямбасүрэн /Ахлах гүйцэтгэгч, хошууч/

С.Бямбарагчаа /Ахлах гүйцэтгэгч, ахлах дэслэгч/

Б.Дашдаваа /Ахлах гүйцэтгэгч, ахмад/

Д.Лхагвасүрэн /Ахлах гүйцэтгэгч, ахмад/

Д.Оюунбаяр /Ахлах гүйцэтгэгч, ахлах дэслэгч/

2. Хамтарсан уулзалтыг дараах байдлаар зохион байгуулсугай. Үүнд:

2.1. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч төлбөр авагч нартай уулзаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралтай байгаа шалтгаан, нөхцөл тэдгээрийг арилгахад нөлөөлөх хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авч хэрэгжүүлэх арга зам зэрэг санал, хүсэлтийг бичгээр /санал асуулгаар/ авч нэгтгэхийг ахлах гүйцэтгэгч /хошууч Н.Уранчимэг/-т,

2.2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч төлбөр төлөгч нартай уулзаж, тэдгээрээс төлбөрөө барагдуулахад саад болж буй хүндрэл, бэрхшээл, цаг үеийн шинжтэй хийгддэг ажлаас шалтгаалдаг эсэх, эрх түдгэлзүүлснээс /хилийн хаалт, дансны хөдөлгөөний хязгаарлалт, үл хөдлөх эд хөрөнгийн хаалт, тусгай

112015000103
2015 tushaal

зөвшөөрөл эзэмших эрх түдгэлзүүлэх гэх мэт/ үүсэх үр дагавар зэргийг бичгээр /санал асуулгаар/ авч нэгтгэхийг ахлах гүйцэтгэгч /ахлах дэслэгч Д.Оюунбаяр/-т,

2.3. Монгол банк, арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын төлөөллөөс төлбөр төлүүлэхээр явуулж буй шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд учирч буй хүндрэл түүнээс гарах гарцыг хуульд хэрхэн тусгуулах /албадан дуудлага худалдаа явуулах журам, хөрөнгийн үнэлгээ хийлгэх шинжээчийн асуудал, зардал, урамшууллын гэрээнд оруулах өөрчлөлт/ талаар санал авч нэгтгэхийг ахлах гүйцэтгэгч /ахмад Д.Лхагвасүрэн/-д,

2.4. Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах эрхтэй хуулийн фирм, өмгөөлөгчийн төлөөллөөс шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудыг төлөөлөхөд учирч буй хүндрэл, гарах гарцыг хуульд хэрхэн тусгуулах, Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ гэх мэт санал хүсэлтийг бичгээр авч нэгтгэхийг ахлах гүйцэтгэгч /хошууч Ц.Бямбасүрэн/-д,

2.5. Нефть импортлогч байгууллагын төлөөллөөс хуульд оруулах санал хүсэлт, Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авах арга хэмжээ зэргийг бичгээр авч нэгтгэхийг /ахлах гүйцэтгэгч, ахмад Б.Дашдаваа/-д,

2.6. Хуулийн байгууллагуудаас санал /Эрүүгийн хуулийн 244, 258, 259, 260 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар цагдаа, прокурорын байгууллагад хандсан, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хариуцлага тооцуулахаар шүүхэд хандсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс гаргавал зохих нотлох баримт, материалыг хэрхэн бүрдүүлэх, хамтран ажиллах талаар/ бичгээр авч нэгтгэхийг ахлах гүйцэтгэгч /ахлах дэслэгч С.Бямбарагчаа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Санал хүргүүлж, авах ажлыг 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс 2015 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хүртэл зохион явуулж, дүнг нэгтгэн 2015 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр дэд дарга, дэд хурандаа Ч.Оюунцэцэгт танилцуулахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

4. Хамтарсан уулзалтыг 2015 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

5. Уулзалт зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг зохих зардлаас гаргахыг /ахлах нягтлан бодогч, ахмад Т.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА

Т.ЭНХБАТ